



**УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ
ТӨМӨР ЗАМЫН ДЭЭД СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар A/68

Улаанбаатар хот

┌ Элсэлтийн журам батлах тухай ─

Дээд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2, 18. БШУ-ны сайдын 2024 оны 03 сарын 20-ны А/143 тоот “Оюутан элсүүлэх журам”, 2024 оны 12 сарын 28-ны А/288 тоот “Босго оноо тогтоох тухай” тушаал, “Төмөр замын дээд сургуулийн дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.2 заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Төмөр замын дээд сургуулийн “2025-2026 оны хичээлийн жилийн бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх журам”-ыг хавсралтаар баталж мөрдсүгэй.

2. Тушаал гарсантай холбогдуулан элсэлтийн бодлого, журам сурталчлан таниулах, элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг сургалт эрхэлсэн дэд захирал (Л.Бямбасүрэн), нийгмийн хөгжил, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал (А.Батсайхан), ерөнхий нягтлан бодогч (Н.Оюунаа) нарт тус тус даалгасугай.

3. Элсэлтийн үйл ажиллагааны явц, үр дүн, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг чанарын үнэлгээ, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн (Т.Алтанцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ  С.ГАЛБАДРАХ

1647250346

2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Төмөр замын дээд сургууль /цаашид ТЗДС гэх/-ийн бакалаврын хөтөлбөрт 2025-2026 оны хичээлийн жилд оюутан элсүүлэхэд МУ-ын Боловсролын ерөнхий хуулийн 14-р зүйл, Дээд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйл, БШУ-ны сайдын 2024 оны 03 сарын 20-ны А/143 тоот “Оюутан элсүүлэх журам”, 2024 оны 12 сарын 28-ны А/288 тоот “Босго оноо тогтоох тухай” тушаал, бусад холбогдох эрх зүйн акт болон энэхүү журам /цаашид журам гэх/-ыг баримтална.
- 1.2 Боловсролын яамнаас тогтоосон шаардлага, дээд боловсролын сургалтын орчны болон холбогдох стандартад нийцүүлэн ТЗДС-ийн удирдах зөвлөл, Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгээс баталсан хяналтын тоонд багтаан ТЗДС-ийн бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлнэ.
- 1.3 ТЗДС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг “бүртгүүлэгч”, элсүүлэх хяналтын тоог “хяналтын тоо”, хяналтын тоонд багтан элсэх эрхээ баталгаажуулсан бүртгүүлэгчийг “элсэгч”, элсэлтийн системийг “элсэлтийн систем”, элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг “элсэлтийн комисс” гэнэ.
- 1.4 ТЗДС-д оюутан элсүүлэх, бүртгэх, баталгаажуулах, мэргэжил сонголт хийлгэх үйл явц ил тод шударга, тэгш хүртээмжтэй байна.
- 1.5 Элсэлтийн комисс нь элсэлтийн үйл ажиллагаатай холбоотой сурталчилгааны материал бэлтгэх, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээгээр хөтөлбөрүүдийг сурталчлах ажлыг зохион байгуулна.

ХОЁР. ЭЛСЭЛТИЙН КОМИСС БАЙГУУЛАХ

- 2.1 Элсэлтийн комиссын бүрэлдэхүүнийг ТЗДС-ийн захирлын тушаалаар томилно.
- 2.2 Элсэлтийн комиссын дарга элсэлтийн үйл ажиллагааг удирдлагаар хангаж, тухайн журмаар зохицуулагдахгүй асуудлыг комиссын хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 2.3 Элсэлтийн комисс хяналтын тоо үлдсэн тохиолдолд нэмэлт элсэлтийг зохион байгуулж болно.

ГУРАВ. ЭЛСЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 3.1 Элсэхийг хүссэн иргэд энэхүү журамтай танилцан, ТЗДС-ийн <https://elselt.xcloud.mn/> элсэлтийн системд бүртгүүлснээр элсэлтийн үйл ажиллагаанд оролцох эрх үүснэ.
- 3.2 Бакалаврын хөтөлбөрт элсэхийг хүсэгч нь бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролтой иргэн байна.
- 3.3 Бүртгүүлэгчийн ЭЕШ-ийн батламж нь шалгалт өгснөөс хойш 2,5 жилийн хугацаанд хүчинтэй байх нөхцөлийг хангасан байх ба бүртгүүлэгч нь 3-аас доошгүй шалгалт өгсөн байна.
- 3.4 Бүртгүүлэгч нь дараах хичээлүүдээр ЭЕШ-ийг өгч, боловсролын яамнаас баталсан үндэсний босго онооны болзлыг хангасан байна. Үүнд:

ТЗДС-д элсэх хөтөлбөрт тавигдах босго онооны жагсаалт:

Хүснэгт 1

№	Индекс	Хөтөлбөрийн нэр	ЭЕШ-1	Босго оноо	ЭЕШ-2	Босго оноо
1	104103	Төмөр замын тээврийн удирдлага, зохион байгуулалт	Математик, Физик	490	Нийгэм судлал, Англи хэл	440
2	041308	Нийлүүлэлтийн сүлжээ логистик	Математик,	490	Нийгэм судлал, Англи хэл	490
3	071606	Зүтгүүр, зүтгүүрийн аж ахуй	Математик, Физик	450	Нийгэм судлал, Англи хэл	450
4	071607	Вагон, вагоны аж ахуй	Математик, Физик	450	Нийгэм судлал, Англи хэл	450
5	071608	Төмөр замын барилга, зам, замын аж ахуй	Математик, Физик	450	Нийгэм судлал, Англи хэл	450
6	071609	Төмөр замын машин ашиглалт	Математик, Физик	450	Нийгэм судлал, Англи хэл	450
7	071403	Төмөр замын автоматик ба телемеханик, холбоо	Математик	490	Физик, Англи хэл	450
8	071310	Цахилгаан хангамж	Математик, Физик	490	Нийгэм судлал, Англи хэл	450
ОХУ-ын Эрхүүгийн Зам харилцааны их сургуультай хамтран хэрэгжүүлдэг 2+3 хөтөлбөр						
9	071403	Төмөр замын автоматик ба телемеханик, холбоо	Математик	490	Физик, Англи хэл	450
10	071608	Төмөр замын барилга, зам, замын аж ахуй	Математик, Физик	450	Нийгэм судлал, Англи хэл	450
БНХАУ-ын Бугатын ТЗК-той шаталсан 3+2 хөтөлбөр						
11		Мэргэжлийн хөтөлбөр	Математик, Нийгэм судлал, Физик, Англи хэл	400	Дурын нэг хичээл	400

3.5 УБТЗ-ын ПТК-ийн МСҮТ-ийн нэг жилийн сургалттай хөтөлбөрийн төгсөгч ЭЕШ-ийг өгч, ТЗДС-ийн бакалаврын хөтөлбөрт тавигдах үндэсний босго онооны болзлыг хангасан тохиолдолд 3.4 заалтын дагуу элсэлтийн бүртгэлд хамрагдана.

3.6 БШУЯ-ны 2024 оны 03 дүгээр сарын 20-ны өдрийн А/143 тоот тушаалаар “Оюутан элсүүлэх журам” -ийн 2.4-р заалтын шалгуурыг хангасан иргэнээс ЭЕШ шаардахгүйгээр элсүүлнэ. Үүнд:

3.6.1 Дэд бакалавр, Бакалаврын боловсролтой иргэн; /төгсөлтийн мэдээлэл ДБУМС-д бүртгэлтэй байх/

- 3.6.2 УБТЗ-ын ПТК-ийн техникчийн хөтөлбөрийн төгсөгч мэргэжлийн чиглэлийн дагуу бакалаврын хөтөлбөрт элсэн суралцах; /голч оноо нь 2,5-с дээш/
- 3.6.3 Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн олон улсын болон улсын төрөлжсөн олимпиадын эхний 5 байрт шалгарсан иргэн тухайн чиглэлийн хөтөлбөрт; /батламж, сертификат нотлох баримтад үндэслэх/
- 3.6.4 Гадаад болон дотоодын ерөнхий боловсролын сургуульд суралцаж бүрэн дунд боловсрол эзэмшин, олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын дүн, оноог Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагаар дүйцүүлэн тооцуулж батламж авсан иргэн;
- 3.6.5 Элсэн суралцах мэргэжлийн чиглэл/хөтөлбөр/-ээр 3-аас доошгүй жил ажилласан, 30-с дээш насны иргэн;

ДӨРӨВ. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ

- 4.1 Элсэлтийн бүртгэл 2025 оны 06 сарын 04-ны өдрийн 09:00 цагаас 06 дугаар сарын 23-ны өдрийн 17:00 цагийн хооронд, ТЗДС-ийн элсэлтийн <https://elselt.xcloud.mn/> системээр, орон даяар цахим хэлбэрээр зохион байгуулагдана.
- 4.2 Бүртгүүлэгч нь цахим элсэлтийн системд бүртгүүлэхдээ БҮТ-ийн системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээр нэвтэрч бүртгүүлэх ба бүртгэлийн хураамж төлөх зөвлөмжтэй танилцан, цахим гүйлгээ хийх эрхтэй банкны картаар гүйлгээ хийж, бүртгэлийн хураамж 15000 төгрөг төлснөөр баталгаажна.
- 4.3 Бүртгүүлэгч нэг бүртгэлийн хураамжаар 2-аас ихгүй хөтөлбөрт бүртгүүлж болно.
- 4.4 УБТЗ ХНН-тэй хамтран ажиллах санамж бичиг байгуулсан чиглүүлэх сургалттай Дархан, УБ, Сайншанд, Замын-Үүдийн лицей сургуулиудын төгсөгчдийг ТЗДС-ийн тухайн хөтөлбөрт, онооны үнэлгээг үндэслэн, хяналтын тоонд багтаан элсүүлнэ. Бүртгүүлэгчийн ЭЕШ-ийн суурь болон дагалдан хичээлийн оноо нь үндэсний босго онооны болзлыг хангасан, 4.2 заалтын дагуу бүртгэлийн хураамжийг төлсөн байна. Энэ нөхцлийг бүртгүүлэгч болзол хангасныг гэрчлэх бичиг баримтыг хуулбар хувийн хамт элсэлтийн комисст 2025 оны 06 сарын 23-ний өдрийн 15 цагт багтаан хүлээлгэн өгч, хүсэлтийг бичгээр гаргана.

ТАВ. ЭРЭМБЭЛЭЛТ, ОНООНЫ ЖАГСААЛТ ГАРГАХ

- 5.1 Элсэлтийн бүртгэл хаагдангуут нийт бүртгүүлэгчдийн ЭЕШ-ийн мэдээллийг БҮТ-ийн серверээс татаж, элсэгчдийн онооны жагсаалтыг гаргана.
- 5.2 Бүртгүүлэгчдийн онооны жагсаалтыг ЭЕШ-1 болон ЭЕШ-2 хичээлийн онооны нийлбэрээр эрэмбэлж, 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 13:00 цагт элсэлтийн <https://elselt.xcloud.mn/> систем болон **Төмөр замын дээд сургууль /Албан ёсны хуудас/** фейсбүүк хуудсаар мэдээлнэ.
- 5.3 Элсэгчдийн нийлбэр оноо тэнцсэн тохиолдолд ЭЕШ-ийн суурь болон дагалдан хичээлийн гүйцэтгэлийн хувийг тооцон байр эзлүүлэх ба гүйцэтгэлийн хувь тэнцвэл боловсролын гэрчилгээний дундаж оноог харгалзана.

ЗУРГАА. МЭРГЭЖИЛ СОНГОЛТ, БАТАЛГААЖИЛТ

- 6.1 Бүртгүүлэгч хяналтын тоонд багтсан эсэхээ онооны жагсаалт гарсны дараа элсэлтийн <https://elselt.xcloud.mn/> системд нэвтэрч шалгана.

- 6.2 Шинээр элсэгчдийн суралцах хөтөлбөрийн сонголт, баталгаажуулалтыг 2025 оны 06 сарын 24,25, 26-ны өдрүүдэд зохион байгуулна.
- 6.3 Бүртгүүлэгч хяналтын тоонд багтаж, элсэх эрхтэй болсноос хойш 72 цагт багтаан ТЗДС-ийн цахим элсэлтийн системд нэвтэрч, 100,000 төгрөгийг төлснөөр элсэн суралцах эрх баталгаажна. Суралцах эрх баталгаажуулсан 100,000 төгрөгийг сургалтын төлбөрт шилжүүлэн тооцно. Элсэх эрхээ баталгаажуулсан тохиолдолд “Суралцах эрхийн бичиг” болон эрүүл мэндийн үзлэгийн хуудас цахимаар олгогдоно.
- 6.4 Элсэгчийн элсэх эрхээ баталгаажуулсан 100,000 төгрөгийг буцаан олгохгүй.
- 6.5 ТЗДС-ийн элсэлтийн хяналтын тоог баримтлан, онооны жагсаалтын дарааллын дагуу нэг элсэгч зөвхөн нэг хөтөлбөр сонгох байдлаар элсэх эрхийн баталгаажуулалт хийгдэнэ.
- 6.6 Суралцах эрх авч, баталгаажуулалт хийсэн элсэгчдэд дахин өөр мэргэжлээр сонголт хийхийг зөвшөөрөхгүй.
- 6.7 Элсэлтийн хяналтын тоонд багтсан боловч хөтөлбөр баталгаажуулаагүй тохиолдолд суралцах эрхийг дараагийн элсэгчдэд шилжүүлэх замаар ил тод, цахим хэлбэрээр зохион байгуулна.

ДОЛОО. ШИНЭ ЭЛСЭГЧИЙГ БҮРТГЭХ

- 7.1 Суралцах эрхийн бичиг авсан элсэгчид <https://elselt.xcloud.mn/> веб хуудсанд нэвтэрч, оюутны цахим анкет бөглөж, 2025 оны 08 сарын 15-ны өдрөөс 29-ний өдрийг дуустал ажлын цагаар ТЗДС-ийн сургалтын албанд өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.
- 7.2 Элсэгч өөрийн биеэр ирэх боломжгүй тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөний хүнийг явуулж бүртгүүлж болно.
- 7.3 Суралцах эрхийн бичиг авсан элсэгчид дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:
- Суралцах гэрээг цахимаар бөглөн, элсэлтийн веб хуудаснаас хэвлэнэ.
 - Иргэний үнэмлэх, эсвэл түүнтэй адилтгах бичиг баримт /эх хувь/, хуулбарын хамт,
 - Бүрэн дунд боловсролын гэрчилгээ /эх хувь/, хуулбарын хамт,
 - ЭЕШ-ийн батламж /эх хувь/,
 - ЕБС-ийн сурагчийн хувийн хэрэг,
 - Сүүлийн 6 сард авхуулсан цээж зураг 3x4 хэмжээтэй 2%,
 - Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан хуудас,
 - Дээрх бичиг баримтыг битүүмжлэл сайтай хавтсанд хийсэн байх. /А4 хэмжээтэй/
- 7.4 Суралцах эрх авсан элсэгчид 2025 оны 06 сарын 24 өдрөөс 08 дугаар сарын 29-ны өдрийг дуустал УБТЗ-ын төв эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамрагдаж, эрүүл мэндээр тэнцсэн байна.
- 7.5 Суралцах эрхийг дараах тохиолдолд хүчингүй болсонд тооцно. Үүнд:
- Суралцах эрхийн бичиг авсан боловч ирж бүртгүүлээгүй, хичээл сонголт хийгээгүй тохиолдолд,
 - Эрүүл мэндийн үзлэгт тэнцээгүй.

НАЙМ. ЭЛСЭГЧДЭД ОЛГОХ ТЭТГЭЛЭГ

- 8.1 МУ-ын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 102-р тогтоолын дагуу Төрөөс олгох санхүүгийн дэмжлэг, буцалтгүй тусламж тэтгэлэг. Үүнд:
- Бүтэн өнчин суралцагч,
 - Эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй өрхийн бакалаврын хөтөлбөрийн нэг суралцагч
 - Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн бакалаврын хөтөлбөрийн нэг суралцагч,
 - Цаатан өрхийн бакалаврын хөтөлбөрийн нэг суралцагч,
 - Нэг өрхийн 3 болон түүнээс дээш хүүхэд дээд боловсролын сургалтын байгууллагад бакалаврын зэргийн боловсрол эзэмшихээр зэрэг суралцаж буй тохиолдолд нэг суралцагч,
- 8.2 УБТЗ-ын ХНН-ийн даргын 2023 оны 02 сарын 28-ны А/210 тоот “Говийн төмөр замчин” хөтөлбөрийн дагуу сургалтын төлбөрийн хөнгөлөлт олгоно.

ЕС. БУСАД

- 9.1 Энэхүү журмын 6.2-д заасан хугацаанд элсэлтийн хяналтын тоо дүүрээгүй тохиолдолд нэмэлт элсэлтийг зарлаж болно. Нэмэлт элсэлт зохион байгуулахтай холбоотой асуудлыг ТЗДС-ийн захирлын тушаалаар шийдвэрлэнэ.
- 9.2 Бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй.
- 9.3 Элсэлттэй холбоотой энэхүү журамд тусгагдаагүй гомдол, маргаантай асуудлыг өргөдөл хүсэлтийг үндэслэн элсэлтийн комисс хянан шийдвэрлэнэ.
- 9.4 Бүртгүүлэгч өөрийн мэдээллийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцна.
- 9.5 Боловсролын яамнаас гаргасан элсэлтийн хугацаа тухайн нөхцөл байдлаас хамааран өөрчлөгдвөл ТЗДС-ийн элсэлт авах хугацаа даган өөрчлөгдөнө.
- 9.5 ТЗДС-ийн элсэлтийн комисстой ажлын өдрүүдэд 08:00-17:00 цагийн хооронд дараах дугааруудаар холбоо барина. Үүнд:

Утас: 21-242273

21-242262